

10

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ: Олон улсад

Б.Даваамаа

ХУРААНГУЙ

Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ) болон бусад зээлийн байгууллагууд нь хугацаа хэтрэх эрсдэл, санхүүжилтийн болон хөрвөх чадварын эрсдэлтэй үргэлж тулгардаг бөгөөд санхүүгийн хямралд хүргэж болзошгүй чанаргүй зээл болон санхүүжилтийн эрсдэлийг байнга хянаж, удирдах шаардлагатай болдог. ХЗХ-дын олон улсын байгууллагаас зохистой харьцааг тооцох PEARLS болон CAMELS гэсэн 2 арга зүйг санал болгодог ба ХЗХ нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг дагаж мөрдөх нь гишүүдийн хадгаламжийн эрсдэлд өртөх магадлалыг бууруулах, үйл ажиллагааг тогтвортой урт хугацаанд явуулах, амьдрах чадварыг нэмэгдүүлэх давуу талуудтай. Энэхүү судалгаагаар Өмнөд Солонгос, Тринидад Тобаго, Кени, Австрали болон Ирланд зэрэг 5 улсын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон олон улсын PEARLS арга зүйг Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дод хүчин төгөлдөр мөрдөгдөж буй зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулан судаллаа.

Түлхүүр үгс: PEARLS арга зүй, CAMEL арга зүй, санхүүгийн гүйцэтгэл.

JEL ангилал: G10, G18, G21

¹ СЗХ, ЗЗСХГ-ын ахлах мэргэжилтэн, davaamaa@frc.mn

АГУУЛГА >>>

I.	УДИРТГАЛ	262
II.	ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	263
	2.1. PEARLS арга зүй.....	263
	2.2. CAMELS арга зүй	266
	2.3. PEARL болон CAMELS арга зүйн ялгаа.....	268
III.	ОЛОН УЛСЫН ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	269
	Өмнөд Солонгос Улс	269
	Тринидад Тобаго Улс	272
	Кени Улс.....	273
	Австрали Улс	275
	Ирланд Улс	276
IV.	МОНГОЛ УЛСЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	278
V.	ДҮГНЭЛТ, САНАЛ	282
VI.	АШИГЛАСАН МАТЕРИАЛ	284

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	PEARLS–ийн зохистой харьцааны гол үзүүлэлт	264
Хүснэгт 2.	CAMELS–ын зохистой харьцааны гол үзүүлэлт	267
Хүснэгт 3.	Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудад тавигдаж буй зохистой харьцаа, хувиар	270
Хүснэгт 4.	Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын зээлийн хэмжээны дээд хязгаар, хувиар	271
Хүснэгт 5.	Банкнаас бусад санхүүгийн байгууллагын зээлийн алдагдлын доод хэмжээ, хувиар	271
Хүснэгт 6.	Олон улсын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	277
Хүснэгт 7.	Монгол Улсын хзх–ны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	279
Хүснэгт 8.	ХЗХ–дын шалгуур үзүүлэлт хангасан байдал, үзүүлэлт тус бүрээр	281
Хүснэгт 9.	ХЗХ–дын шалгуур үзүүлэлт хангасан байдал, хзх тоогоор, хувиар	282

I. УДИРТГАЛ

Гишүүдийнхээ эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг хангах зорилгоор гишүүддээ хадгаламж, зээлийн үйлчилгээг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үзүүлэх ардчилсан удирдлага, хамтын хяналт бүхий ашгийн төлөө бус хуулийн этгээдийг Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ) гэнэ. ХЗХ болон бусад зээлийн байгууллагууд нь хугацаа хэтрэх эрсдэл, санхүүжилтийн болон хөрвөх чадварын эрсдэлтэй үргэлж тулгардаг бөгөөд санхүүгийн хямралд хүргэж болзошгүй чанаргүй зээл болон санхүүжилтийн эрсдэлийг байнга хянаж, удирдах шаардлагатай болдог.

Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын зөвлөл (WOCUU)-өөс ХЗХ-дод зохистой харьцааг тооцох PEARLS арга зүйг санал болгодог. Тус арга зүйг 1986 онд Гватемал Улс ХЗХ-дын үйл ажиллагаанд нэвтрүүлснээр ХЗХ-ны системийн эрсдэлийн асуудлууд шийдэгдэж үйл ажиллагаа нь тогтворжсоноор олон улсын ХЗХ-дын хэрэглээнд нэвтэрч эхэлжээ. Харин 1979 онд АНУ-ын Холбооны Нөөцийн банк (Federal Reserve Bank)-аас арилжааны банкны санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийх, мөн газар дээрх шалгалтаар байгууллагад үнэлгээ өгөх зорилгоор CAMELS арга зүйг ашиглаж эхэлсэн ба 1987 онд Америкийн Нэгдсэн Улсын Үндэсний зээлийн холбооны захиргаа (NCUA)-наас ХЗХ-дод хэрэгжүүлж эхэлснээр олон улсын санхүүгийн байгууллагууд хүлээн зөвшөөрсөн хяналтын болон үнэлгээний систем бий болсон.

ХЗХ нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг дагаж мөрдөх нь гишүүдийн хадгаламжийг эрсдэлд өртөх магадлалыг бууруулах, үйл ажиллагаа нь тогтвортой урт хугацаанд явуулах, амьдрах чадварыг нэмэгдүүлэх давуу талуудтай. Улс орнуудын ХЗХ-д гол төлөв дээрх

2 арга зүйг ашиглан зохистой харьцааг тооцон дагаж мөрддөг.

Монгол Улсын хувьд PEARLS арга зүйг ашигладаг бөгөөд анхны “ХЗХ-ны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн журам”-ыг 2008 онд баталсан ба түүнээс хойш 5 удаагийн өөрчлөлт оруулан хүчин төгөлдөр мөрдөж байна. 2024 оны I улирлын байдлаар ХЗХ-дын 33.7 хувь нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан бол 6.0 хувь нь 5 болон түүнээс дээш зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллаагүй байна. Үүнийг задалбал ХЗХ-дын 4.3 хувь нь эрсдэлийн санг дутуу байгуулж, 12.0 хувь нь чанаргүй зээлийн зохистой харьцаа, 33.7 хувь нь нийт хөрөнгөд эзлэх цэвэр зээлийн зохистой харьцаа, 11.4 хувь нь хадгаламжийн зохистой харьцаа, 16.3 хувь нь хоршоологчдын өмчийн зохистой харьцаа болон 27.2 хувь нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг тус тус хангаж ажиллаагүй байна. Ийнхүү эдгээр харьцааг мөрдөж ажиллаагүй тохиолдолд төлбөр түргэн гүйцэтгэх чадвар буурч санхүүгийн тогтвортой байдал алдагдах нөхцөл бүрдэн хадгаламж эзэмшигчдийг хохироох, үйл ажиллагаа тасалдах зэрэг эрсдэлүүд үүснэ.

Иймд энэхүү судалгаагаар Өмнөд Солонгос, Тринидад Тобаго, Кени, Австрали болон Ирланд зэрэг 5 улсын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон олон улсын PEARLS арга зүйг Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дод хүчин төгөлдөр мөрдөгдөж буй зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулан судалж, Монгол Улсын ХЗХ-дын зохистой харьцаа дээр санал, зөвлөмжийг дэвшүүлсэн.

Энэхүү судалгааны ажил нийт 5 бүлэгтэй. Хоёрдугаар бүлэгт ХЗХ-ны зохистой харьцааны

шалгуур үзүүлэлтийг тооцох арга зүйн талаар танилцуулна. Судалгааны гурав, дөрөв дүгээр бүлэгт харгалзан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн олон улсын туршлага, Монгол

Улсын өнөөгийн байдлын талаар тусгасан. Харин эцсийн тавдугаар бүлэгт дүгнэлт, зөвлөмжийг оруулав.

II. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2.1. PEARLS АРГА ЗҮЙ

PEARLS нь 45 санхүүгийн харьцааг ашиглан ХЗХ–ны санхүүгийн гүйцэтгэл, эрүүл мэндийг хэмжих арга зүй юм. Тус хэрэгсэл нь байгууллагын санхүүгийн тайлангийн тоон мэдээлэлд тулгуурлан санхүүгийн асуудлыг богино хугацаанд илрүүлэхэд чиглэгдсэн бөгөөд хөгжиж буй орнуудын ХЗХ–дын санхүүгийн үзүүлэлтийг стандартчилж, бүх хоршоодын гүйцэтгэлийг үнэлж, хооронд нь харьцуулах боломжийг олгодог.

1986–1994 онд Гватемал Улсад иргэний дайны дараа ХЗХ–дын зээлийн өрийн үлдэгдэл нэмэгдсэнээр төлбөрийн чадваргүй болж уналтад орсон. Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын зөвлөл нь Гватемалын Үндэсний зээлийн холбоотой хамтран зээлийн хоршоодод техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн хүрээнд ХЗХ–дын үйл ажиллагаанд PEARLS–ийн арга зүйг ашигласан. Ингэснээр ХЗХ–ны системийн асуудлууд шийдэгдэж үйл ажиллагаа нь тогтворжиж тус арга зүй ХЗХ–дын хэрэглээнд нэвтэрч эхэлжээ.

PEARLS нь Protection–хөрөнгийн хамгаалалт, Effective financial structure–үр өгөөжтэй санхүүгийн бүтэц, Asset quality–Хөрөнгийн чанар, Rates of return and cost–зардал өгөөжийн түвшин, Liquidity–хөрвөх чадвар, болон Sign

of growth–өсөлтийн дохио гэсэн үгсийн эхний үсгийн товчлол юм. Мөн PEARLS арга зүй дараах зорилтуудыг хангадаг:

1. *Гүйцэтгэх удирдлагын хэрэгсэл:* ХЗХ–ны үйл ажиллагаанд хяналт тавих нь PEARLS системийн хамгийн чухал хэрэглээ юм. Энэ нь асуудлыг энгийн байдлаар тодорхойлохоос гадна удирдлагын хэрэгсэл болж байгууллагын асуудал, дутагдлыг арилгах цаашлаад шийдлийг олоход тусалдаг. Жишээлбэл, PEARLS систем нь хөрөнгийн чанар султай ХЗХ–ны асуудлын шалтгааныг (жишээлбэл, нийт орлого бага, үйл ажиллагааны зардал өндөртэй эсвэл хэт их хэмжээний алдагдалтай) хурдан бөгөөд үнэн зөв тодорхойлж, асуудал хүндрэхээс өмнө шаардлагатай зохицуулалт хийх боломжийг олгодог. Үндсэндээ PEARLS бол удирдлагын хувьд шаардлагатай мэдээллийн баазыг бий болгодог “эрт дохиоллын систем” юм.

2. *Стандартчилгдсан үнэлгээний харьцаа ба томьёо:* Стандартчилсан санхүүгийн харьцаа, томьёог бүх нийтээр нэгэн зэрэг ашиглах нь ХЗХ–дын үйл ажиллагааг үнэлэхэд ашиглах санхүүгийн хэлийг бий болгодог.

3. *Харьцуулах, зэрэглэл тогтоох:* Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон PEARLS–

ийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг хослуулан ашигласнаар ХЗХ-дыг харьцуулан зэрэглэл тогтоох боломж бүрддэг. Стандартчилсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлт бий болохоос өмнө өөр өөр шалгуур, тайлагналын форматаас хамааран нэг ХЗХ-г нөгөөтэй нь харьцуулах боломжгүй байсан бол санхүүгийн мэдээллийн стандартчилал нь олон талт байдлыг арилгаж, ХЗХ-дын гүйцэтгэлийг үндэсний хэмжээнд харьцуулах үр дүнтэй хэрэгсэл болсон. PEARLS-ийн харьцуулсан зэрэглэлийн нэг чухал тал бол түүний бодитой байдал юм. Учир нь тус хэрэгсэлд чанарын болон субъектив үзүүлэлтүүд багтдаггүй.

4. Хяналт тавих үйл ажиллагааг хөнгөвчлөх: PEARLS систем нь удирдлагын хэрэгсэл болохоос

гадна зохицуулагч байгууллагын хяналтын нэгжийн гол хэрэглүүр болдог. Зохицуулагч байгууллага нь PEARLS-ийн санхүүгийн харьцааг ашиглан ХЗХ-ны үйл ажиллагааны бүх гол гүйцэтгэлүүдэд сар, улирал бүрээр дүн шинжилгээ хийх боломжтой. Эдгээр үнэлгээ нь байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийг хэмжиж тухайн салбаруудын гол асуудлуудыг илрүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулдаг. Харин зохицуулагч байгууллагын хянан шалгагчид ХЗХ-дын мэдээлсэн санхүүгийн тайлан, харьцааны найдвартай байдлыг хадгалахад гол үүрэг гүйцэтгэх ёстой.

Мөн PEARLS-ийн зохистой харьцааны 45 үзүүлэлт үзүүлэлтийг Хүснэгт 1-д харуулав.

Хүснэгт 1. PEARLS-ийн зохистой харьцааны гол үзүүлэлт

Хэсэг	Код	Тодорхойлолт	Шалгуур
P = PROTECTION /Хөрөнгийн хамгаалалт/	P1	Зээлийн эрсдэлийн сан/ Хугацаа хэтэрсэн өр төлбөр >12 сар	100%
	P2	Зээлийн эрсдэлийн сан/ Хугацаа хэтэрсэн өр төлбөр 1–12 сар	35%
	P3	Зээлийн эрсдэлийн сан/ Хугацаа хэтэрсэн өр төлбөр 1–12 сар	100%
	P4	Хугацаа хэтэрсэн зээлийн төлбөр >12 сар	Тийм
	P5	Жилийн зээлийн төлбөр/ Дундаж зээлийн багц	Минимумчлах
	P6	Хуримтлагдсан зээлийн эргэн төлөлт/Хуримтлагдсан зээлийн төлбөр	>75%
	P7	Төлбөрийн чадвар	Минимум 111%
E = EFFECTIVE FINANCIAL STRUCTURE /Үр өгөөжтэй санхүүгийн бүтэц/	E1	Цэвэр зээл/Нийт хөрөнгө	70–80%
	E2	Хөрвөх чадвартай хөрөнгө оруулалт/ Нийт хөрөнгө	Махимум 16%
	E3	Санхүүгийн хөрөнгө оруулалт/ Нийт хөрөнгө	Махимум 2%
	E4	Санхүүгийн бус хөрөнгө оруулалт/ Нийт хөрөнгө	0%
	E5	Хадгаламж / Нийт хөрөнгө	70–80%
	E6	Бусдаас авсан зээл/ Нийт хөрөнгө	Махимум 5%
	E7	Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө / Нийт хөрөнгө	Махимум 20%
	E8	Хоршоологчдын өмч / Нийт хөрөнгө	Минимум 10%
	E9	Цэвэр хоршоологчдын өмч / Нийт хөрөнгө	Минимум 10%

A = ASSET QUALITY /Хөрөнгийн чанар/	A1	Нийт хугацаа хэтэрсэн зээл / Нийт зээлийн багц	<=5%
	A2	Үндсэн хөрөнгө/ Нийт хөрөнгө	<=5%
	A3	Цэвэр хоршоологчдын өмч болон шилжилтийн капитал + Хүүгийн бус өр төлбөр/ үндсэн хөрөнгө	>200%
	R1	Цэвэр зээлийн орлого/ Дундаж цэвэр зээлийн багц	Бизнес эрхлэгчдийн хувь хэмжээ
R = RATES OF RETURN & COSTS /Зардал өгөөжийн хувь/	R2	Хөрвөх чадвартай хөрөнгө оруулалтын орлого/ Дундаж хөрвөх чадвартай хөрөнгө оруулалт	Зах зээлийн өсөлт
	R3	Санхүүгийн хөрөнгө оруулалтын орлого/ Санхүүгийн дундаж хөрөнгө оруулалт	Зах зээлийн өсөлт
	R4	Санхүүгийн хөрөнгө оруулалтын орлого/ Санхүүгийн бус дундаж хөрөнгө оруулалт	>= R1
	R5	Хадгаламжийн нийт хүүгийн зардал/ Дундаж хадгаламж	Зах зээлийн өсөлт >Инфляц
	R6	Бусдаас авсан зээлийн нийт хүүгийн зардал/ Дундаж бусдаас авсан зээл	Зах зээлийн өсөлт
	R7	Хувьцааны нийт хүү (ногдол ашиг) зардал/ Гишүүдийн дундаж хувь оруулсан хөрөнгө	Зах зээлийн өсөлт >= R5
	R8	Нийт ахиуц орлого/ Дундаж нийт хөрөнгө	R10, R12–ийг нөхөхөд шаардлагатай хэмжээ
	R9	Үйл ажиллагааны нийт зардал/ Дундаж нийт хөрөнгө	<=5%
	R10	Зээлийн эрсдэлийн сангийн нийт зардал/ Дундаж нийт хөрөнгө	Хугацаа хэтэрсэн зээлээс хамаарна
	R11	Тогтмол бус орлого, зардал/ Дундаж нийт хөрөнгө	Минимум
	R12	Цэвэр орлого/ Дундаж нийт хөрөнгө (ROA)	E8–аас хамаарна
	R13	Цэвэр орлого/ Хоршоологчдын өмч + Шилжилтийн капитал	> инфляцын түвшин
	L = LIQUIDITY /Хөрвөх чадвар/	L1	(Хөрөнгө оруулалт + Хөрвөх чадвартай хөрөнгө – Өглөг) / Хадгаламж
L2		Хөрвөх чадвартай хөрөнгө / Хадгаламж	Минимум 10%
L3		Орлого авчирдаггүй хөрвөх чадвартай хөрөнгө/ Нийт хөрөнгө	<1%
S = SIGNS OF GROWTH /Өсөлтийн шинж тэмдэгүүд/	S1	Зээлдэгчдийн өсөлт	E1–ээс хамаарна
	S2	Хөрвөх чадвартай хөрөнгө оруулалтын өсөлт	E2–ээс хамаарна
	S3	Санхүүгийн хөрөнгө оруулалтын өсөлт	E3–ээс хамаарна
	S4	Санхүүгийн бус хөрөнгө оруулалтын өсөлт	E4–ээс хамаарна
	S5	Хадгаламжийн өсөлт	E5–ээс хамаарна
	S6	Бусдаас авсан зээлийн өсөлт	E6–ээс хамаарна

S7	Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн өсөлт	E7–ээс хамаарна
S8	Байгууллагын хөрөнгө оруулалтын өсөлт	E8–ээс хамаарна
S9	Байгууллагын цэвэр хөрөнгө оруулалтын өсөлт	E9–ээс хамаарна
S10	Гишүүнчлэлийн өсөлт	Минимум 15%
S11	Нийт хөрөнгийн өсөлт	>инфляц + 10%

Эх сурвалж: World Council of Credit Union

2.2. CAMELS АРГА ЗҮЙ

CAMELS арга зүйг 1987 онд Үндэсний зээлийн холбооны захиргаанаас ХЗХ–дод хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү систем нь олон улсын санхүүгийн байгууллагууд хүлээн зөвшөөрсөн хяналтын болон үнэлгээний систем болсон. CAMELS нь Capital adequacy–хөрөнгийн үзүүлэлт, Asset quality–хөрөнгийн чанар, Management soundness–Удирдлагын тогтвортой байдал, Earnings and profitability–Орлого ба ашигт байдал, Liquidity–хөрвөх чадвар, Sensitivity–зах зээлийн мэдрэмж гэсэн үгсийн эхний үгсийн товчлол ба санхүүгийн байгууллагын гүйцэтгэлийн 6 бүрэлдэхүүн хэсгийг үнэлдэг хяналтын болон үнэлгээний систем юм. Тус систем нь санхүүгийн байгууллагын тогтвортой байдал болон эрүүл мэндийг үнэлэхдээ хянан шалгагчийн үнэлгээ болон газар дээрх шалгалтад тулгуурладаг. Ингэснээр санхүү, удирдлага, засаглалын нийтлэг хүчин зүйлс нь жигд бөгөөд цогц байдлаар үнэлэгддэг.

CAMELS аргачлал нь дараах 6 зорилготой:

- ХЗХ–дын хөрөнгийн хүрэлцээг (C) хянаж, үнэлгээ хийж, богино хугацаанд бий болох санхүүгийн хүндрэлийг хэрхэн зохицуулж байгааг тодорхойлох;
- Байгууллагуудын багц дахь хөрөнгийн янз бүрийн эрсдэлд өртөх магадлалыг

судлахын тулд хөрөнгө оруулалт, зээлийг онцолж хөрөнгийн чанарыг (A) үнэлж, хэмжих;

- Хүний нөөц, үйл явц, хяналт, аудит зэрэг засаглал, удирдлагын хяналтыг үнэлж, дүгнэх замаар ХЗХ–дын удирдлагын (M) ерөнхий зөв, үр дүнтэй байдлыг шалгадаг;
- ХЗХ–дын орлого, ашигт ажиллагааны хүрэлцээг (E) судалж, хангалттай хөрөнгийн баазыг бүрдүүлэх, өргөтгөлийг санхүүжүүлэх, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах замаар алдагдлыг шингээх чадварт анхаарлаа хандуулдаг;
- Хөрвөх чадвар (L)–ын байдал ба хүрэлцээ нь ХЗХ–дын одоогийн болон хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний хэрэгцээ, түүний дотор зээлийн эрэлт, хувьцааг эргүүлэн татах болон бусад зардлуудыг хангах чадамжийг шалгадаг;
- Зах зээлийн эрсдэлд мэдрэмтгий байдал (S) нь зээлийн хүү, валютын ханшийн гэнэтийн тохируулгад зээл, хадгаламжийн мэдрэмтгий байдлыг судалдаг.

Дээр дурдсанчлан CAMELS үнэлгээг санхүүгийн тайлангийн харьцааны дүн шинжилгээ, хянан шалгагчийн газар дээрх шалгалтын үр дүнтэй хослуулан тогтоодог. Тус үнэлгээний систем нь байгууллагын үйл ажиллагааг үнэлэхдээ санхүүгийн болон үйл ажиллагааны бүхий л чухал хүчин зүйлсийг харгалзан үзэх, тусгах зорилготой юм. Үнэлгээг 1–5 хүртэлх оноогоор дүгнэдэг. 1 эсвэл 2 гэсэн үнэлгээ нь ХЗХ–д хяналт шалгалтын

асуудал багатайг илэрхийлдэг бөгөөд энэ нь тогтвортой үйл ажиллагааг хангадаг эрсдэлийн удирдлагын практик, хангалттай гүйцэтгэлийг харуулж байна. Үүний эсрэгээр 3, 4, 5 гэсэн үнэлгээ нь тус ХЗХ нь дунд зэргийн болон хэт өндөр эрсдэлтэй, хангалтгүй муу гүйцэтгэлийг илтгэнэ.

Мөн CAMELS–ийн зохистой харьцааны үзүүлэлтийг Хүснэгт 2–д харуулав.

Хүснэгт 2. CAMELS–ын зохистой харьцааны гол үзүүлэлт

Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд	Зохистой харьцааны үзүүлэлт
Хөрөнгийн хүрэлцээ	Эрсдэлээр жигнэсэн хөрөнгө
	Эрсдэлээр жигнэсэн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө
Хөрөнгийн чанар	Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн эзлэх хувь
	Чанаргүй зээлээс капиталын эрсдэлийг хассан
	Нийт зээл дэх салбарын зээлийн хуваарилалт
Удирдлага	Засаглал, хүний нөөц, үйл явц, хяналт, аудитыг шалгах замаар байгууллагын удирдлагын ерөнхий оновчтой, үр дүнтэй байдал
Орлого ба ашигт ажиллагаа	Хөрөнгийн өгөөж
	Өөрийн хөрөнгийн өгөөж
	Нийт орлогод эзлэх цэвэр хүүгийн орлого
	Нийт орлогод эзлэх цэвэр хүүгийн бус зардал
Хөрвөх чадвар	Нийт хөрөнгөд эзлэх эргэлтийн хөрөнгө
	Нийт хөрөнгөд эзлэх богино хугацааны өр төлбөр
Зах зээлийн эрсдэлд мэдрэмтгий байдал	Валютын хөрөнгийн цэвэр нээлттэй позиц

Эх сурвалж: Federal Financial Institutions Examination Council, 1979

2.3. PEARL БОЛОН CAMELS АРГА ЗҮЙН ЯЛГАА

PEARLS болон CAMELS арга зүйн гол ялгаа нь үнэлгээ байдаг. PEARLS-ийн хувьд холбогдох 45 харьцаа үзүүлэлтийг шинжилж, ХЗХ-ны санхүүгийн байдал, гүйцэтгэлийг үнэлдэг бол CAMELS арга зүйн хувьд газар дээр шалгалт хийн тухайн нөхцөл байдалд тохирсон оноог хянан шалгагч өгдөг. Иймд CAMELS арга зүйн хувьд хянан шалгагчийн үзэл бодол, хандлага нөлөөлөх магадлал өндөр байдаг. Мөн түүнчлэн, PEARLS-ийн үзүүлэлтүүдийн шалгуур түвшнийг үйл ажиллагаа нь тогтворжсон эсвэл шинээр байгуулагдсан ХЗХ-ны онцлог, хэрэгцээнд тохируулан өөрчлөх боломжтой. Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын зөвлөл (WOCPU) нь АНУ-ын CAMELS-ийн үзүүлэлтүүдийг PEARLS-ийн арга зүйд ашиглаж ХЗХ-дод тохируулах оролдлогыг хийсэн боловч олон өөрчлөлт хийх шаардлага үүссэн төдийгүй хоёр томоохон дутагдлыг илрүүлсэн:

1. CAMELS нь балансын санхүүгийн бүтцийг үнэлдэггүй. Харин балансын бүтэц нь ХЗХ-ны үйл ажиллагаанд шууд нөлөөлдөг.
2. CAMELS хөрөнгийн өсөлтийн хурдыг тооцдоггүй. Олон улс оронд нийт хөрөнгийн өсөлт нь мөнгөний ханшийн уналт, инфляцыг дагалддаг асуудлуудыг шийдвэрлэхэд ашигладаг гол стратеги юм.

CAMELS нь удирдлагын хэрэгсэл гэхээсээ илүү хяналтын хэрэгсэл болон бүтээгдсэн.

CAMELS-ийн харьцааны гол зорилго нь байгууллагын төлбөрийн чадвар, гишүүдийн хадгаламжийн аюулгүй байдлыг хамгаалах юм. CAMELS үнэлгээний систем нь ХЗХ-ны үйл ажиллагааны зургаан (6) чухал элемент болох санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийн үнэлгээнд суурилдаг. Үнэлгээний систем нь ХЗХ-ны үйл ажиллагааг үнэлэхдээ санхүүгийн болон үйл ажиллагааны бүх чухал хүчин зүйлийг харгалзан үзэж тусгадаг. CAMELS тогтолцоо нь зөвхөн тоон үзүүлэлт дүгнэхээс гадна хяналтын мэдээллийг олж авдаг давуу талтай.

Харин PEARLS нь хянан шалгагчийн ерөнхий субъектив дүгнэлтийг өөртөө агуулдаггүй, удирдлагад тоон үнэлгээ өгдөг тул CAMELS системээс ялгаатай юм. Субъектив үнэлгээнээс зайлсхийснээр ХЗХ-ны тайлангаас авсан санхүүгийн мэдээллээр нотлогдсон бодитой харьцааг гаргаж авах боломжтой. Мөн энэхүү систем нь ХЗХ-ны тэргүүлэгчдийн зөвлөл болон байгууллагын захирлууд асуудлыг цаг хугацаа алдахгүй нээлттэй хэлэлцэх ба боломжийг олгодог.

Тодруулбал, PEARLS систем нь санхүүгийн харьцааг ашигладаг хяналтын хэрэгсэл, ХЗХ-дыг харьцуулах зэрэглэл тогтоох, өндөр гүйцэтгэлийг дэмжих бизнес төлөвлөлтийн хэрэгсэл болон бусад функцуудыг агуулдаг. Бүрэлдэхүүн хэсэг бүрийн хувьд ХЗХ-дын үйл ажиллагааны үнэлгээнд санхүүгийн багц харьцааг ашигладаг.

III. ОЛОН УЛСЫН ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

3.1. ӨМНӨД СОЛОНГОС УЛС

Өмнөд Солонгос Улсын хувьд санхүүгийн байгууллагуудыг банк, банкнаас бусад санхүүгийн байгууллага, санхүүгийн хөрөнгө оруулалтын үйлчилгээ үзүүлэгч, даатгалын компани гэсэн дөрвөн төрөлд ангилдаг.

Эдгээр санхүүгийн байгууллагуудад тусгай зөвшөөрөл олгох, санхүүгийн зах зээлийн эрх зүйн орчныг бүрдүүлэх сайжруулах, зах зээлийн бодлого явуулах чиг үүргийг Санхүүгийн үйлчилгээний хороо (Financial Services Commission) хэрэгжүүлдэг бол хууль, дүрэм, журмын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавьдаг байгууллага нь Санхүүгийн хяналтын алба (Financial Supervisory Service) юм.

Дээр дурдсанчлан, ХЗХ нь банкнаас бусад санхүүгийн байгууллага гэсэн ангилалд багтдаг бөгөөд ХЗХ–г зээлийн хоршоо, хөдөө аж ахуй, загас, ойн аж ахуйн хоршоо, олон нийтийн ХЗХ хэмээн ангилдаг. Үүнээс олон нийтийн ХЗХ нь Дотоод хэргийн болон Аюулгүй байдлын яам (Ministry of the Interior and Safety)–ны хяналтад байдаг бөгөөд бусад нь Санхүүгийн хяналтын албаны хяналтад байдаг.

Санхүүгийн хяналтын алба нь банкнаас бусад санхүүгийн байгууллагуудад үнэлгээ хийж зэрэглэл тогтоохдоо CAMELS арга зүйг ашиглан хөрөнгийн хүрэлцээ, активын чанар, удирдлага, ашиг орлого, хөрвөх чадвар гэсэн 5 бүрэлдэхүүн хэсэгт дүн шинжилгээ хийж, хянан шалгалт хийдэг. Банкнаас бусад санхүүгийн

байгууллагуудад дараах нийтлэг 6 зохистой харьцаа тавьж байна (FSS handbook, 2021). Үүнд:

1. Өөрийн хөрөнгийн харьцаа;
2. Хөрвөх чадварын харьцаа (дотоод болон гадаад мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдсэн);
3. Зээл, хадгаламжийн харьцаа;
4. Чанаргүй зээлийн харьцаа;
5. Зээлийн алдагдал ба нөөцийн харьцаа;
6. Зээлийн хэмжээг сунгах дээд хязгаар.

Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудад тавигдаж буй зохистой харьцааны үзүүлэлтийг Хүснэгт 3–т харуулав. Үүнээс харахад Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудад тавигдаж буй харьцаа нь үйлчилгээний онцлогоос хамааруулан өөр өөр байна. Тухайлбал, өөрийн хөрөнгийн харьцаа нь дундын хадгаламжийн банканд 7 хувиас багагүй, мерчант банкнууд болон зээлийн үйлчилгээний компаниудад 8 хувиас багагүй байхаар тусгагдсан бол ХЗХ–ны хувьд цэвэр хөрөнгийн харьцаагаар илэрхийлэгдсэн байна. Энэхүү харьцаа нь хамгийн багадаа 2 хувь байна.

Түүнчлэн, ХЗХ–ны үйл ажиллагаанд хөрвөх чадварын болон чанаргүй зээлийн харьцаа тогтоогоогүй бол зээл–хадгаламжийн харьцааг 100 хувь, зээлийн алдагдал ба нөөцийн харьцаа (эрсдэлийн сан)–г 100 хувь байхаар мөрдөж ажиллах ёстой.

² Цэвэр хөрөнгийн харьцаа=Татвар төлсний дараах цэвэр ашиг ч (Хувь нийлүүлэгчдийн хөрөнгө + Хуримтлагдсан ашиг)

Хүснэгт 3. Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудад тавигдаж буй зохистой харьцаа, хувиар

Үзүүлэлтүүд	Дундын хадгаламжийн банк	ХЗХ	Мерчант банкууд	Зээлийн үйлчилгээ компаниуд
Өөрийн хөрөнгийн харьцаа	7%	цэвэр ашгийн харьцаа 2%	8%	8%
Хөрвөх чадварын харьцаа (Дотоод мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдсэн)	100%	–	100%	100%
Хөрвөх чадварын харьцаа (Гадаад валютаар илэрхийлэгдсэн)	–	–	80%	80%
Зээл–хадгаламжийн харьцаа (max)	100%	100%	–	–
Чанаргүй зээлийн харьцаа	–	–	–	10% /Зөвхөн зээлийн үйлчилгээ үзүүлэгч компаниудад тавигддаг/
Зээлийн алдагдал ба нөөцийн харьцаа (min)	100%	100%	–	–

Эх сурвалж: FSS Handbook 2021

Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын дагаж мөрдөх зээлийн хэмжээний дээд хязгаарын мэдээллийг Хүснэгт 4–т харуулав. ХЗХ–ны хувьд нэг гишүүнд олгох зээлийн хэмжээ нь өөрийн хөрөнгийн 20 хувь, эсхүл нийт хөрөнгийн 1 хувиас хэтрэхгүй байна гэсэн ерөнхий шалгуур тавьдаг ч зээлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь тухайн тохиолдлоос хамааран өөр өөр байдаг. Тухайлбал, өөрийн хөрөнгийн 20 хувьтай тэнцэхүйц мөнгөн дүн нь нийт хөрөнгийн 1 хувиас их байвал зээл олгох дээд хэмжээг 5–10 тэрбум вон хүртэл нэмэгдүүлж болно. Эсрэг тохиолдолд зээл олгох дээд хэмжээ

700 сая воноор хязгаарлагддаг. Харин гол төлөв өрхийн хэрэглээний зээл олгодог бол ХЗХ нь зээл олгох дээд хэмжээг нэмэгдүүлэх эрхгүй ба зарим төрлийн ХЗХ–дын нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн дээд хэмжээнд хязгаарлалт тавьдаг байна.

Мөн ХЗХ нь гишүүдээс татан төвлөрүүлсэн хадгаламжийн 10–аас доошгүй хувийг заавал байлгах нөөцөд, 50–иас доошгүй хувийг Үндэсний холбооны дансанд байршуулж, үлдсэнийг нь бэлэн мөнгө, бусад санхүүгийн байгууллагуудад хадгаламж хэлбэрээр байршуулсан байх ёстой.

Хүснэгт 4. Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын зээлийн хэмжээний дээд хязгаар, хувиар

	Дундын хадгаламжийн банк	ХЗХ	Мерчант банкнууд	Зээлийн үйлчилгээ компаниуд
Нэг хувь хүн хуулийн этгээдэд олгох зээл	Хөрөнгийн 20%-иас хэтрэхгүй байна: –Хувьцаат компанийн хувьд: 10 тэрбум вон; –хувиараа бизнес эрхлэгчийн хувьд: 5 тэрбум вон; –Хувь хүний хувьд: 800 сая вон;	Өөрийн хөрөнгийн 20%, эсвэл хөрөнгийн 1%-ийн аль ихээр;	Өөрийн хөрөнгийн 25%	–
Нэг хүн болон нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээл	Өөрийн хөрөнгийн 25%	–	Өөрийн хөрөнгийн 25%	–
Том зээлийн өргөтгөл, хязгаар	Өөрийн хөрөнгийн 500%	–	Өөрийн хөрөнгийн 25%	–
Гол хувьцаа эзэмшигч болон тусгайлан хамаарал бүхий аливаа этгээдэд зээлийн сунгалт	Зээлийн дээд хязгаарыг нэмэгдүүлэхийг зөвшөөрдөггүй;	–	Өөрийн хөрөнгийн 25%-иас хэтрэхгүй	Өөрийн хөрөнгийн 50%

Эх сурвалж: FSS Handbook 2021

Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын зээлийг 5 ангилалд хуваах ба ХЗХ нь хэвийн зээлийн 1 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн 10 хувь, хэвийн бус зээлийн 20 хувь, эргэлзээтэй

зээлийн 55 хувь, муу зээл 100 хувьтай тэнцэхүйц хэмжээгээр зээлийн эрсдэлийн санг байгуулдаг (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Банкнаас бусад санхүүгийн байгууллагын зээлийн алдагдлын доод хэмжээ, хувиар

	хэвийн	хугацаа хэтэрсэн зээл	Чанаргүй зээл			
			хэвийн бус	эргэлзээтэй	муу	
Дундын хадгаламжийн банк	1%	10%	20%	55%	100%	
ХЗХ	1%	10%	20%	55%	100%	
Мерчант банкнууд	0.5%	2%	20%	50%	100%	
Зээлийн үйлчилгээ компаниуд	Өрхийн зээл	1%	10%	20%	75%	100%
	Хэсэгчилсэн санхүүжилтийн авлага /Installment finance receivables/	1%	10%	20%	75%	100%
	Зээлийн картын авлага	1.1%	40%	60%	75%	100%
	Зээлийн картын зээл	2.5%	50%	65%	75%	100%
	Бусад	0.5%	1%	20%	75%	100%

Эх сурвалж: FSS Handbook 2021

3.2. ТРИНИДАД ТОБАГО УЛС

Тринидад Тобаго Улсын ХЗХ-ны тухай хууль нь³ 2009 онд батлагдсан бөгөөд тус хуулийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий байгууллага нь Төв банк юм. Төв банкны зүгээс ХЗХ-ны эрх зүйн орчныг бүрдүүлэх, сайжруулах санал боловсруулахдаа Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын зөвлөлөөс тогтоосон олон улсын стандартууд болон ХЗХ-ны салбар хөгжсөн улс орнуудын сайн туршлагыг харгалзан үзэж өөрийн орны онцлогт тохируулан ашигладаг бөгөөд ХЗХ-ны санхүүгийн гүйцэтгэлийг үнэлэх, зэрэглэл тогтоохдоо PEARLS-ийн арга зүйг ашигладаг.

ХЗХ-ны тухай хуульд заасны дагуу ХЗХ-ны хоршоологчдын өмчийн нийт хөрөнгөд эзлэх хувь нь 8 хувиас багагүй байх ба хэрэв ХЗХ тус зохистой харьцааг хангаагүй тохиолдолд гишүүдэд ногдол ашиг олгохыг хязгаарладаг. Мөн ХЗХ-ны үл хөдлөх хөрөнгийн эзэмшлийн хэмжээг бизнес эрхлэхэд шаардлагатай үл хөдлөх хөрөнгө, ажилчдыг орон сууцжуулахаас бусад тохиолдолд нийт хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй байхаар тогтоосон.

Харин төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хувьд нийт өр төлбөрт эзлэх хөрвөх чадвартай хөрөнгийн хувийг хамгийн багадаа 15 хувь байхаар хадгалах шаардлагатай бол үйл ажиллагааны зардлыг нийт хөрөнгийн 5 хувиар хязгаарлах ёстой.

ХЗХ-ны чанаргүй зээлийн дээд хэмжээ нийт зээлийн багцын 4.5 хувиас хэтрэхгүй харин тус байгууллагын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл болон төсөл, хөтөлбөрийн зээл нь нийт хөрөнгийн 8 хувиас хэтрэхгүй байна. Нийт хөрөнгөд эзлэх хоршоологчдын өмчийн 12 хувийг хангаж буй тохиолдолд энэхүү хязгаарыг 10 хувь хүртэл нэмэгдүүлэх боломжтой.

ХЗХ-ны аливаа нэг байгууллага, хувь гишүүн, эсвэл нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн дээд хэмжээ нь өөрийн хөрөнгийн 25 хувиас хэтрэхгүй байна. Энэхүү хязгаар нь дараах тохиолдолд хамаарахгүй:

- Тринидад ба Тобаго Улсын Засгийн газраас 100 хувийн батлан даалт гаргасан;
- Тринидад ба Тобаго Улсын Засгийн газраас өөр бүрэн эрхт улсаас 100 хувийн батлан даалт гаргасан;
- Тринидад ба Тобаго доллар болон бусад гадаад мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдсэн зээлийг 100 хувь төлөх боломжит дүнтэй хадгаламжийг барьцаалсан.

ХЗХ нь хугацаа хэтэрсэн зээлийг цаг тухайд нь тодорхойлж, зээлийн боломжит алдагдлыг нөхөх хангалттай эрсдэлийн санг байгуулах үүрэгтэй. Уг сан нь зээлийн багцын үнийн дүнгийн 0.5–4.5 хувьтай тэнцэхүйц байна. Төв банкнаас зээлийн эх үүсвэрийг бүхэлд нь эсхүл аль нэг хэсэгт нь хэсэгчлэн нөхөх дараах санг байгуулахыг шаардаж болно:

- хэвийн бус зээлийн 20 хувь;
- эргэлзээтэй зээлийн 50 хувь;
- муу зээлийн 100 хувь.

Цаашлаад зээл нь “чанаргүй” ангилалд багтсан хэдий ч үл хөдлөх хөрөнгөөр бүрэн баталгаажсан, түүнийг хураах шатандаа байгаа эсхүл бэлэн мөнгө, хувьцаагаар зуун хувь баталгаажсан тохиолдолд ямар нэгэн эрсдэлийн сан үүсгэх шаардлагагүй.

Тринидад Тобаго Улсын Төв банкнаас хадгаламжийн нийт хөрөнгөд эзлэх хувь,

³ https://www.central-bank.org.tt/sites/default/files/page-file-uploads/Credit%20Unions%20%28Prudential%20Criteria%29%20Regs%202012_0_0.pdf

зээлийн зохистой харьцаа, нөөц сан болон хадгаламж хамгаалалтын сангийн хоршоологчдын өмчид эзлэх хувь, нэг гишүүний оруулсан хувь хөрөнгийн хэмжээнд зохистой харьцаа тогтоогоогүй байна. Гэсэн хэдий ч ХЗХ нь жил бүр цэвэр ашгийн 20 хувийг нөөц

санд байршуулах ба хадгаламж хамгаалалтын санд байршуулах мөнгөн дүнг өөрийн дотоод дүрмээр зохицуулах, мөн нийт гишүүдийн оруулсан хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувийг эзэмшдэг гишүүдийн мэдээллийг Төв банканд мэдээлэх үүрэгтэй.

3.3. КЕНИ УЛС

Кени Улсын ХЗХ-г ХЗХ-ны нийгэмлэгийг зохицуулах газар (The Sacco Societies Regulatory Authority) зохицуулдаг. Тус зохицуулагч байгууллага нь 2008 онд батлагдсан⁴ ХЗХ-ны нийгэмлэгийн тухай хуулийн дагуу гишүүдээсээ хадгаламж татан төвлөрүүлэх, зээл олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, тэдгээр үйл ажиллагааг зохицуулах, хянан шалгалт хийх, ХЗХ-оос цуглуулсан зохицуулалтын үйл ажиллагааны төлбөрийг эзэмших, захиран зарцуулах, ашиглах, шимтгэл хураах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг.

ХЗХ-ны нийгэмлэгийн тухай хуулийн дагуу ХЗХ-ны хөрөнгө нь дараах зохистой харьцааны шалгуурыг хангасан байх ёстой:

- үндсэн хөрөнгийн хэмжээ 10 сая шиллингээс багагүй;
- үндсэн хөрөнгө нь нийт хөрөнгийн 10 хувиас багагүй байна. Үүнээс газар, барилга байгууламж 5 хувиас хэтрэхгүй;
- хоршоологчдын өмч нь нийт хөрөнгийн 8 хувиас багагүй;
- үндсэн хөрөнгө нь хадгаламжийн 8 хувиас багагүй байна.

Хэрэв зохицуулагч байгууллагын зүгээс ХЗХ-г эрсдэлд өртөх өндөр магадлалтай, эсхүл хөрөнгийн чанарын үзүүлэлт муудсан,

эрсдэлийн удирдлагын тогтолцоо султай, хараат болон охин компаниудын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх магадлалтай хэмээн үзэж хөрөнгийн доод хэмжээг нэмэгдүүлэх шаардлагыг хүргүүлсэн бол ХЗХ нь хөрөнгийн хэмжээгээ заавал нэмэгдүүлэх үүрэгтэй. Түүнчлэн, ХЗХ нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй, холбогдох шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд зохицуулагч байгууллага дараах захиргааны шийтгэлүүдийн аль нэгээр нь эсвэл бүгдийг нь авч хэрэгжүүлж болно:

- зээл олгох, хөрөнгө оруулалтыг авах үйл ажиллагааг түр зогсоох;
- нэмэлт газар, барилга байгууламжийг худалдан авах, түрээслэхийг хориглох;
- цаашид хадгаламж татан төвлөрүүлэх болон бусад зээл авахыг хориглох;
- эрх бүхий байгууллагаас авч хэрэгжүүлэх бусад зохих арга хэмжээ.

Тус улсын ХЗХ-дын дагаж мөрдөх төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа 15 хувь⁵ бөгөөд энэхүү зохистой харьцааг хадгалахын тулд ХЗХ-ны Тэргүүлэгчдийн зөвлөл нь жил бүр хөрвөх чадварын удирдлагыг хариуцах болон зээлийн шугамд хандах албан тушаалтныг томилдог, мөн нийт мөнгөн хөрөнгийн доод ба дээд хязгаар, бэлэн мөнгө эзэмших хязгаар,

⁴ Энэхүү хууль нь 2022 онд шинэчлэгдэн батлагдсан.

⁵ ХЗХ нь хадгаламж болон богино хугацаат өр төлбөрийнхөө 15 хувийг хөрвөх чадвартай хөрөнгөөр хадгална.

хөрөнгийн болон хөрвөх чадварын удирдлагын хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх заавар, хөрөнгө, хөрвөх чадварын байдалд дүн шинжилгээ хийх давтамж зэргийг багтаасан бодлогын баримт бичгийг боловсруулах, түүнд хяналт тавьж ажиллах үүргийг хүлээдэг. Тэргүүлэгчдийн зөвлөл нь хөрвөх чадварын хямралыг шийдвэрлэх онцгой байдлын төлөвлөгөөг баталдаг. Төлөвлөгөөнд онцгой байдлын үед хөрвөх чадварын дутагдлыг нөхөх, санхүүжилтийн хэвийн үйл ажиллагаа алдагдсан нөхцөлд хөрвөх чадварыг нөхөх стратегийг тусгасан байх ёстой.

Зохицуулагч байгууллагаас зохистой харьцааны дээд хязгаарыг нэмэгдүүлэх эрх олгоогүй тохиолдолд ХЗХ-ны банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл, төсөл, хөтөлбөрийн зээл нь нийт хөрөнгийн 25 хувиас хэтрэхгүй байх ёстой. Харин бусдаас авсан зээл дээрх хязгаарлалтаас хэтрэх тохиолдолд зохистой харьцааны үзүүлэлтийн дээд хязгаарыг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулсан нарийвчилсан тайлбарыг агуулсан баримт бичгийг өргөдлийн хамт зохицуулагч байгууллагад хүргүүлнэ. Хэрэв ХЗХ-оос санал болгож буй зээлийн хязгаар нь тус байгууллагын үйл ажиллагаанд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй хэмээн зохицуулагч байгууллага үзсэн тохиолдолд тус хязгаарыг нэмэгдүүлэх эрхийг олгодог.

Гишүүддээ зээл олгох зорилгоор гаднын байгууллагаас зээл авч байгаа ХЗХ нь уг гаднын зээлд төлөх хүүгээс хамгийн багадаа 2 хувиар өндөр хүүгээр гишүүддээ зээл олгох ба ХЗХ-ны

нэг гишүүнд олгох зээлийн хэмжээ нь үндсэн хөрөнгийн 10 хувиас хэтрэхгүй байна.

Мөн ХЗХ нь зээлийг дараах байдлаар ангилах ба зээлийн эрсдэлийн санг байгуулна:

- хэвийн зээлийн 1 хувь;
- хугацаа хэтэрсэн зээлийн 5 хувь;
- хэвийн бус зээлийн 25 хувь;
- эргэлзээтэй зээлийн 50 хувь;
- муу зээл 100 хувь.

Түүнчлэн, Кени Улсын ХЗХ-дын зохицуулагч байгууллага нь чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь, хадгаламжийн нийт хөрөнгөд эзлэх хувь, нийт зардалд эзлэх үйл ажиллагааны зардлын хувь, нөөц сан болон хадгаламж хамгаалалтын сангийн хоршоологчдын өмчид эзлэх хувь, нэг гишүүний оруулсан хувь хөрөнгийн хэмжээнд зохистой харьцаа тогтоогоогүй байна. Хэдийгээр дээр дурдсан үзүүлэлтүүдэд зохистой харьцаа тогтоогоогүй ч ХЗХ нь жил бүр цэвэр ашгийн 20 хувийг нөөц санд байршуулах, мөн нийт гишүүдийн оруулсан хөрөнгийн 10 хувь, хадгаламжийн 20 ба түүнээс дээш хувийг эзэмшдэг гишүүдийн мэдээллийг Төв банканд мэдээлэх үүрэгтэй. Цаашлаад, Сангийн сайдын баталсан журмын дагуу⁶ хадгаламжийн батлан даалтын санд жил бүр 50,000 шиллинг эсхүл нийт хадгаламжийн 0.175 хувьтай тэнцэх хэмжээний шимтгэл хоёрын аль өндрийг төлдөг. Хадгаламжийн батлан даалтын сан нь ХЗХ-дын гишүүн бүрийн хувьд 100,000 шиллинг хүртэлх хэмжээний хадгаламжийг эрсдэлээс хамгаалах чадамжтай.

⁶ Хадгаламжийн батлах даалтын санд татан төвлөрүүлэх мөнгөн дүн жил бүр өөр өөрөөр тогтоодог.

3.4. АВСТРАЛИ УЛС

Австрали Улсын хадгаламжийн байгууллагууд, даатгал болон тэтгэврийн сангийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий байгууллага нь Австралийн зохистой байдлын зохицуулалтын газар (Australian Prudential Regulation Authority) юм. Австрали Улсын Төв банкны тухай хуульд тодорхойлсны дагуу Хадгаламжийн байгууллага (ADI) гэдэг нь Зохицуулах байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр олон нийтээс хадгаламж татах эрх бүхий санхүүгийн байгууллага юм.

Хадгаламжийн байгууллагын төрлүүд:

Банк: Арилжааны банкууд нь хадгаламж татан төвлөрүүлдэг байгууллагын хамгийн нийтлэг төрөл болно. Эдгээр байгууллага нь хадгаламж хүлээн авах, зээл олгох, төлбөр тооцоог хийх зэрэг олон төрлийн санхүүгийн үйлчилгээг санал болгодог.

Барилгын нөхөрлөл: Барилгын нийгэмлэгүүд нь орон сууцны зээл олгож, олон нийтээс хадгаламж татан төвлөрүүлдэг байгууллага юм.

ХЗХ: Зөвхөн гишүүдээс хадгаламж хүлээн авах, зээл санал болгох, санхүүгийн бусад үйлчилгээ үзүүлдэг.

Гадаадын охин банк: Эдгээр нь Австралид үйл ажиллагаа явуулдаг гадаадын өмчит банк юм.

Гадаадын банкны салбарууд: Австралид үйл ажиллагаа явуулдаг гадаадын банкны салбарууд.

Австрали Улс бол олон улсын хамгийн найдвартай, тогтвортой санхүүгийн системтэй улс орнуудын нэг юм. Австралийн зохистой байдлын зохицуулалтын газрын хяналтад байдаг хадгаламжийн байгууллагууд нь нэгэн ижил зохистой харьцааг дагаж мөрддөг. Тухайлбал өөрийн хөрөнгийн доод хэмжээ нь хадгаламжийн 8 хувь, харин төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа хамгийн багадаа

9 хувь байна. Түүнчлэн ХЗХ-ны нэг гишүүн болон нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон зээлийн зохистой харьцааг ХЗХ-ны зээлийн бодлогын баримт бичигт тусган дагаж мөрддөг байхаар хуульчилсан. Мөн нэг гишүүний оруулж болох хувь хөрөнгө 20 хувиас хэтрэхгүй бөгөөд нөөц сангийн хэмжээг хамгийн багадаа хоршоологчдын өмчийн 2.5 хувьтай тэнцүү байхаар тогтоожээ.

Хадгаламж хамгааллын сангийн хувьд 2008 оны дэлхийн санхүүгийн хямралын оргил үед Австрали Улс нь хэрэглэгчдийн хадгаламжийг хамгаалах нэмэлт давхарга буюу Санхүүгийн нэхэмжлэлийн схем (Financial Claims Scheme)–ийг бий болгосон. Санхүүгийн нэхэмжлэлийн схем нь банк, ХЗХ, барилгын нийгэмлэг зэрэг Австралийн хадгаламж хүлээн авах эрх бүхий байгууллагын хадгаламж эзэмшигчид болон ердийн даатгалд даатгуулагчдын хувьд нэмэлт хамгаалалт төдийгүй хадгаламж, нөхөн төлбөрийг шуурхай авах боломжийг олгодог. Санхүүгийн нэхэмжлэлийн схем нь хадгаламжийн байгууллагын данс эзэмшигч бүрийн 250,000 доллар хүртэлх хадгаламжийг хамгаалах засгийн газрын дэмжлэгтэй хамгаалалтын схем юм. Тус схем нь ердийн даатгалын хувьд 5,000 доллар хүртэлх нөхөн төлбөрийг авах боломжтой ба тодорхой шалгуурыг хангасан тохиолдолд 5,000 доллароос дээш нөхөн төлбөр авах боломжтой. Хадгаламжийн байгууллага эсвэл Ердийн даатгалын компани үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд Засгийн газар үүрэг болгосны дагуу Австралийн зохистой байдлын зохицуулалтын газар нь Санхүүгийн нэхэмжлэлийн схемийг идэвхжүүлэх эрхтэй. Энэ нь Австрали доллароор хадгалагдаж буй гүйлгээ, хадгаламж, чекийн данс, хугацаатай хадгаламж, ипотекийн офсет данс зэрэг өргөн хүрээний данснуудыг хамруулдаг.

3.5. ИРЛАНД УЛС

Ирланд Улсын ХЗХ–ны тухай хууль 1966 онд анх батлагдаж, 1997, 2013, 2015, 2016, 2018 онуудад өөрчлөлт орсон ба тус хуулийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий байгууллага нь Төв банк юм. 2018 оны ХЗХ–ны гарын авлага⁷–д дурдсанаар Төв банкнаас дараах зохистой харьцааг ХЗХ–д үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахаар тогтоосон:

- Нэг гишүүнд олгох зээлийн зохистой харьцаа;
- Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа;
- Хадгаламжийн зохистой харьцаа;
- Бусдаас авсан зээлийн зохистой харьцаа;
- Нөөцийн сангийн хэмжээ;
- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа.

ХЗХ–ны тухай хуульд заасны дагуу ХЗХ нь хэрэглээний зээл, бизнесийн зээл, нийтийн зээл, орон сууцны зээл болон бусад ХЗХ–дод зээл олгох эрхтэй. ХЗХ–ны нэг гишүүнд (хувь хүн) олгох зээлийн дээд хэмжээ зохицуулалттай нөөц⁸–ийн 2.5 хувиас хэтрэхгүй ба нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн дээд хэмжээ зохицуулалттай нөөцийн 10 хувь эсхүл 39,000 еврогоос хэтрэхгүй байна. Цаашлаад орон сууцны зээл, бизнесийн зээлийн хувьд тус зээлийн өрийн үлдэгдэл нийт хөрөнгийн 7.5 хувиас хэтрэхгүй. Хэрэв ХЗХ нь тодорхой шаардлагыг хангасан тохиолдолд орон сууцны зээл болон бизнесийн зээлтэй холбоотой нийт өрийн үлдэгдлээ ХЗХ–ны хөрөнгийн 10 болон 15 хувь хүртэл нэмэгдүүлэх боломжтой. Ийнхүү хязгаарыг 10 хувь хүртэл нэмэгдүүлэх тохиолдолд тухайн ХЗХ нь сүүлийн 2 улирал дараалан хамгийн багадаа 50 сая еврогийн нийт актив, нийт хөрөнгөд эзлэх зохицуулалтын нөөц нь 12.5 хувиас багагүй

байна. Харин 15 хувь хүртэл нэмэгдүүлэх тохиолдолд сүүлийн 2 улирал дараалан хамгийн багадаа 100 сая еврогийн нийт хөрөнгөтэй байна гэсэн шаардлагыг хангасан байх шаардлагатай. Мөн зээлийн дээд хязгаарыг нэмэгдүүлэх тухай мэдэгдлээ бичгээр гаргаж холбогдох шаардлагыг хангаж байгааг нотолсон баримт бичгийн хамт 30 хоногийн өмнө Төв банканд хүргүүлнэ.

Харин хадгаламжийн зохистой харьцааны хувьд ХЗХ–ны нэг гишүүн хамгийн ихдээ 100,000 еврогийн хадгаламжтай байна. ХЗХ нь гишүүн бүрийнхээ нийт хадгаламжийг тооцож 100,000 еврогоос бага эсэхийг баталгаажуулах үүрэгтэй бөгөөд ингэхдээ гишүүн бүрийн бүх төрлийн дансанд байгаа хадгаламжийг харгалзан үзнэ. Энэ нь гишүүн бүрийн эзэмшдэг дансны тооноос үл хамааран нийт 100,000 хүртэлх еврогийн хадгаламж эзэмших боломжтой гэсэн үг юм.

ХЗХ–ны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа нь хадгаламжийн 20 хувиас багагүй байна. Нэг зээлдэгч гишүүн нь нийт хадгаламжийн 25 хувиас ихгүй мөнгөн дүн бүхий зээлийг барьцаагаар болон бусад хэлбэрээр авч болно.

Нэмж дурдахад, Ирланд Улс нь 2021 онд ХЗХ–дын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг банкны салбарт ашигладаг Базел III арга зүйн дагуу тооцох оролдлогыг хийсэн. Базел III арга зүйг олон улсын банкнуудтай адил хөрөнгө, өр төлбөрийн нарийн бүтэцтэй тохиолдолд ашиглах боломжтой. Тухайлбал, Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын зөвлөл нь ХЗХ–дод Базел III арга зүйг ашиглахыг зөвлөдөггүй. Иймээс ХЗХ–дын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, шинэчлэх ажлын хэсэг дээр дурдсан шалтгааны улмаас Базел III арга зүйг ХЗХ–нд хэрэгжүүлэхийг дэмжээгүй болно.

⁷ ХЗХ–ны дагаж мөрдөх бүх дүрэм, журам, хууль багтсан баримт бичиг.

⁸ Хадгаламж зээлийн хоршоо нь хөрөнгийн 10–аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний зохицуулалтын нөөцийг хадгална.

Хүснэгт 6. Олон Улсын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

	Зохистой харьцааны үзүүлэлтүүд	PEARLS	Монгол Улс	Австрали Улс	Кени Улс	Ирланд Улс	Өмнөд Солонгос Улс	Тринидад Тобаго Улс
1	Чанаргүй зээлийн зохистой харьцаа	<5%	<5 %	-	-	-	-	<4.5
2	Нэг гишүүнд олгосон зээлийн зохистой харьцаа	-	<30%	ХЗХ-ны зээлийн бодлогын баримт бичигт тусгадаг	<10% ⁹	<2.5% ¹⁰	Өөрийн хөрөнгийн 20%, эсвэл хөрөнгийн 1%-ийн аль ихээр	<25%
3	Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон зээлийн зохистой харьцаа	-	<30%	ХЗХ-ны зээлийн бодлогын баримт бичигт тусгадаг.	<10%	<10% ¹¹	-	<25%
4	Нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцаа	70%-80%	60%-85%	-	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	<5%	<10%	-	<10%, 10,000,000 шиллингээс багагүй; <8%	<10%	Цэвэр ашгийн харьцаа 2% байхаар	<5%
6	Хадгаламжийн зохистой харьцаа	70%-80%	20%-80%	-	-	€100,000	-	-
7	Бусдаас авсан зээлийн зохистой харьцаа	<5%	<20%	-	<25%	<25%	-	<8% Хэрэв ХНХ нь 12%-аас их байвал 10%
8	Нэг гишүүний оруулж болох хувь хөрөнгө	<20%	<10%	20%	10%	10% ¹²	-	20%
9	Нөөцийн сангийн хэмжээ		>3%	>2.5%	Цэвэр ашгийн 20%-ийг жил бүр байршуулна.	>10% ¹³	Хадгаламжийн 10 хувийг заавал нөөц санд байршуулна.	Цэвэр ашгийн 20 хувиас хэтрэхгүй
10	Хоршоологчдын өмчийн зохистой харьцаа	>10%	>5%	-	>8%	-	-	>8%
11	Хадгаламж хамгаалалтын сангийн хэмжээ	-	>5%	\$250,000 хүртэлх хадгаламжийг хадгална.	0.175% эсхүл, 50,000 шиллинг	-	Нөөц сангийн 50 доошгүй хувь	Хоршоо өөрийн дүрмээр зохицуулна

⁹ ХЗХ нь үндсэн хөрөнгийн 10 хувиас хэтэрсэн зээл олгохгүй.

¹⁰ Зохицуулалттай нөөцийн 2.5 хувиас ихгүй.

¹¹ Зохицуулалттай нөөцийн 10 хувиас ихгүй.

12	Тогтворжилтын сангийн хэмжээ	-	>5%	Хөрөнгийн ангилалд хамаарах хөрвөх чадварын эрсдэлээс хамааруулан тооцно.	-	-	-	-
13	Үйл ажиллагааны зардлын зохистой түвшин	<5%	<15%	-	-	-	-	<5%
14	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	>10%	>4%	>9% ¹⁴	>15% ¹⁵	>20%	-	>15%

IV. МОНГОЛ УЛСЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсын анхны “ХЗХ–ны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн журам”–ыг 2008 онд Монголбанк баталсан ба түүнээс хойш 2012, 2013, 2014, 2018, 2020 онуудад 5 удаагийн өөрчлөлт оруулсан (Хүснэгт 7). Харин одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “ХЗХ–ны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн журам” нь 4 бүлгийн 16 зохистой харьцаанаас бүрддэг. Үүнд:

1. Хөрөнгийн чанарын болон хамгаалалтын үзүүлэлт:

1. Активын эрсдэлийн сангийн хүрэлцээ;
2. Чанаргүй зээлийн зохистой харьцаа;
3. Нэг гишүүнд олгосон зээлийн зохистой харьцаа;

4. Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон зохистой харьцаа.

2. Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт:

1. Нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцаа;
2. Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа;
3. Гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа;
4. Бусдаас авсан зээлийн зохистой харьцаа;
5. Нэг гишүүний оруулж болох хувь хөрөнгийн зохистой харьцаа;
6. Хоршоологчдын өмчийн зохистой харьцаа;
7. Нөөцийн сангийн байвал зохистой харьцаа;

¹² Нийт гишүүдийн оруулсан хөрөнгийн 10 ба түүнээс дээш хувийг эзэмшдэг гишүүдийн мэдээллийг Төв банканд мэдээлэх үүрэгтэй

¹³ Нийт хөрөнгийн 10 хувьтай тэнцэнэ.

¹⁴ Түргэн хөрвөх хөрөнгийн өр төлбөрт эзлэх хувиар тооцдог.

¹⁵ ХЗХ нь хадгаламж болон богино хугацаат өр төлбөрийн 15 хувийг хөрвөх чадвартай хөрөнгөөр байршуулах ёстой.

8. Хадгаламж хамгаалалтын сангийн байвал зохих доод хэмжээ;
9. Тогтворжилтын сангийн байвал зохих доод хэмжээ.

3. Өгөөж, зардлын хувь хэмжээний үзүүлэлт:

1. Үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа;
2. Хөрөнгийн өгөөж.

4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт:

1. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа.

Эдгээр зохистой харьцааг тооцож мөрдөж ажилласнаар ХЗХ өөрийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлж, сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлж үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж ажиллах нөхцөл бүрддэг. Түүнчлэн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаанаас бусад харьцаа үзүүлэлтийг тооцох аргачлал нь өнөөдөр Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын зөвлөлөөс гишүүн орнууддаа дагаж мөрдөхийг санал болгож буй аргачлалын тооцоололтой ижил байна.

Хүснэгт 7. Монгол Улсын ХЗХ-ны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

	PEARLS	2008.07.07	2012.03.14	2013.03.13	2014.01.29	2014.01.29 Нийслэлийн хөтөлбөрт	2017.01.01 Нийслэлийн хөтөлбөрт	2018.06.29	2020
Активын эрсдэлийн сангийн хүрэлцээ	-	-	-	-	-	-	-	-	-
Чанаргүй зээлийн зохистой үзүүлэлт	<5%	<5%	<5%	<5%	<5%	<5%	<5%	<5%	<5%
Зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлт	-	<30%	<30%	<30%	<30%	<5 сая	<30%	<30%	<30%
1 гишүүнд олгосон зээлийн зохистой харьцаа	-	-	-	-	<30%	<5 сая	<30%	<30%	<30%
Нийт актив хөрөнгөд эзлэх зээлийн хэмжээ	70–80%	50–80%	60–80%	60–80%	60–85%	60–95%	60–85%	60–85%	60–85%
ӨБҮХ-ийн зохистой харьцаа/Нийт актив	-	<5%	<5%	<5%	-	>5%	-	-	-
Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа/нийт актив	<5%	<5%	<10%	<10%	<10%	<10%	<10%	<10%	<10%

Гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа	70–80%	0–80%	0–80%	0–80%	20–80%	5–80%	20–80%	20–80%	20–80%
Бусдаас авсан зээлийн зохистой харьцаа	<5%	<10%	<20%	<20%	<20%	–	<20%	<20%	<20%
Гишүүдийн хоршоологчдын өмчийн зохистой харьцаа	>10%	>10%	>10%	–	>5%	–	>5%	>5%	>5%
Нөөцийн сангийн байвал зохих доод хэмжээ	>5%	>15%	>15%	>15%	>5%	>5%	>5%	>5%	>3%
Үйл ажиллагааны зардлын зохистой түвшин	<5%	<5%	<15%	<15%	<15%	<15%	<15%	<15%	<15%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	>10%	>5%	>5%	>5%	>5%	>5%	>5%	>5%	>4%
Активын өгөөж	2%	–	–	–	–	–	–	–	–
1 гишүүний оруулж болох хувь хөрөнгийн хэмжээ	<20%	–	<10%	<10%	<10%	<10%	<10%	<10%	<10%
Хадгаламж хамгаалалтын сан	–	–	–	–	>5%	>10%	>5%	>5%	>5%
Тогтворжилтын сан	–	–	–	–	>5%	>10%	>5%	>5%	>5%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, Хадгаламж, зээлийн хоршоодын одоо мөрдөж буй зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг үнэлэх, сайжруулах туршилт үнэлгээний тайлан

ХЗХ–дын 2024 оны I улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулгад дурдсанаар 184 ХЗХ–д Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр өөрийн 73,293 гишүүдэд санхүүгийн үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд нийт ХЗХ–дын 17.4 хувь нь зээлийн эрсдэлийн санг илүү байгуулсан бол нийт ХЗХ–дын 4.3 хувь нь дутуу байгуулсан байна. Нийт ХЗХ–дын 12.0 хувь нь чанаргүй зээлийн зохистой харьцаа, 33.7 хувь нь

нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцаа, 11.4 хувь нь гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа, 9.2 хувь нь бусдаас авсан зээлийн зохистой харьцаа, 16.3 хувь нь хоршоологчдын өмчийн зохистой харьцаа, 1.1 хувь нь үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа, 27.2 хувь нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг тус тус хангаж ажиллаагүй байна. ХЗХ–ны зах зээлийн хөрөнгийн өгөөж 0.6 хувь байна (Хүснэгт 8).

Хүснэгт 8. ХЗХ–дын шалгуур үзүүлэлт хангасан байдал, үзүүлэлт тус бүрээр

№	Үзүүлэлт	Байвал зохих	Хангаагүй ХЗХ–дын тоо	Хувь
Хөрөнгийн чанар болон хамгаалалтын үзүүлэлт				
1	Хөрөнгө /актив/–ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+ илүү, –дутуу)	134,354.19 мян.төг (32 ХЗХ) –15,823.52 мян.төг (8 ХЗХ)	40	21.7%
2	Чанаргүй зээлийн зохистой харьцаа	5%–аас хэтрэхгүй	22	12.0%
3	Нэг гишүүнд олгосон зээлийн зохистой харьцаа	30%–аас хэтрэхгүй	10	5.4%
4	Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон зээлийн зохистой харьцаа	30%–аас хэтрэхгүй	1	0.5%
Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт				
5	Нийт хөрөнгө /актив/–д эзлэх зээлийн зохистой харьцаа	60%–85%	62	33.7%
6	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	10%–аас хэтрэхгүй	4	2.2%
7	Гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа	20%–80%	21	11.4%
8	Бусдаас авсан зээлийн зохистой харьцаа	20%–аас хэтрэхгүй	17	9.2%
9	Нэг гишүүний оруулж болох хувь хөрөнгийн зохистой харьцаа	10%–аас хэтрэхгүй	3	1.6%
10	Хоршоологчдын өмчийн зохистой харьцаа	5%–аас доошгүй	30	16.3%
11	Нөөцийн сангийн байвал зохих доод хэмжээ	3%–аас доошгүй	24	13.0%
12	Хадгаламж хамгаалалтын сангийн байвал зохих доод хэмжээ	5%–аас доошгүй	6	3.3%
13	Тогтворжилтын сангийн байвал зохих доод хэмжээ	5%–аас доошгүй	8	4.3%
Зардлын зохистой хэмжээ				
14	Үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа	15%–аас хэтрэхгүй	2	1.1%
15	Хөрөнгө /актив/–ийн өгөөж	0.6%		
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар				
16	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа	4%–аас доошгүй	50	27.2%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, ХЗХ–дын 2024 оны I улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

ХЗХ–дын 33.7 хувь буюу 62 ХЗХ зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан бол 6.0 хувь буюу 11 ХЗХ

5 болон түүнээс дээш зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллаагүй байна (Хүснэгт 9).

Хүснэгт 9. ХЗХ–дын шалгуур үзүүлэлт хангасан байдал, ХЗХ тоогоор, хувиар

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	ХЗХ–дын тоо	Хувь
1	Шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан	52	27.2%
2	1 ЗХШҮ хангаагүй	55	28.8%
3	2 ЗХШҮ хангаагүй	31	16.2%
4	3 ЗХШҮ хангаагүй	19	9.9%
5	4 ЗХШҮ хангаагүй	13	6.8%
6	5 ЗХШҮ хангаагүй	21	11.1%
7	Нийт дүн	191	100%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, ХЗХ–дын 2024 оны I улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

V. ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлаар Өмнөд Солонгос, Тринидад Тобаго, Кени, Австрали, Ирланд зэрэг 5 улсын ХЗХ–ны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн зохицуулалтын туршлагыг судаллаа. Эдгээр улс орнуудын ХЗХ–дод мөрдүүлдэг зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн туршлагаас харахад Өмнөд Солонгос, Тринидад Тобаго, Ирланд Улсын хувьд үндсэн хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх зохистой харьцааг 5–10 хувиас хэтрэхгүй байхаар, Кени Улсын хувьд тус зохистой харьцааг 10 сая шиллингээс багагүй байх мөнгөн дүнгээр тогтоодог бол Австрали Улс тус харьцаанд шалгуур үзүүлэлт тогтоогоогүй байна. Харин төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа нь тус улс орнуудын хувьд хамгийн багадаа 9–20 хувь байхаар тогтоогджээ.

Нэг гишүүнд олгох зээлийн дээд хязгаарыг Кени Улс 10 хувиас, Тринидад Тобаго Улс 25 хувиас тус тус хэтрэхгүй байхаар, Австрали Улс нь ХЗХ өөрийнхөө зээлийн бодлогын баримт бичигт тусгаж мөрдүүлэхээр зохицуулсан бол Өмнөд Солонгос Улсын хувьд ХЗХ–ны хувьд нэг гишүүнд олгох зээлийн хэмжээ нь өөрийн хөрөнгийн 20 хувь, эсхүл нийт хөрөнгийн 1 хувиас хэтрэхгүй байна гэсэн ерөнхий шалгуур тавьдаг. Гэсэн хэдий ч зээлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь тухайн тохиолдлоос хамааран өөр өөр байдаг. Тухайлбал, өөрийн хөрөнгийн 20 хувьтай тэнцэхүйц мөнгөн дүн нь нийт хөрөнгийн 1 хувиас их байвал зээл олгох дээд хэмжээг нь 5–10 тэрбум вон хүртэл нэмэгдүүлж болно. Эсрэг тохиолдолд зээл олгох дээд хэмжээ 700 сая воноор хязгаарлагддаг.

Харин Тринидад Тобаго Улсын хувьд бусдаас авсан зээлийн зохистой харьцааг шатлалтай тогтоосон бол Ирланд Улс нь орон сууцны зээл олгох зээлийн дээд хязгаарыг шатлалтай тогтоожээ. Тухайлбал, ХЗХ–ны банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл болон төсөл, хөтөлбөрийн зээл нийт хөрөнгийн 8 хувиас хэтрэхгүй байх ёстой хэдий ч нийт хөрөнгөд эзлэх хоршоологчдын өмчийн 12 хувийг хангаж буй тохиолдолд энэхүү хязгаарыг 10 хувь хүртэл нэмэгдүүлэх боломжтой.

Мөн Ирланд Улсын хувьд зээлийн харьцаанд орон сууцны зээл, бизнесийн зээлийн хувьд тус зээлийн өрийн үлдэгдэл нийт хөрөнгийн 7.5 хувиас хэтрэхгүй байхаар тусгасан. Хэрэв ХЗХ нь тодорхой шаардлагыг хангасан тохиолдолд орон сууцны зээл болон бизнесийн зээлтэй холбоотой нийт өрийн үлдэгдлээ ХЗХ–ны хөрөнгийн 10 болон 15 хувь хүртэл нэмэгдүүлэх боломжтой.

Ирланд Улс нь хадгаламж хамгааллын бодлогын хүрээнд хадгаламжийн мөнгөн дүнгээр зохистой харьцаа тавьдгаараа бусад улсаас онцлогтой. Тухайлбал ХЗХ–ны нэг гишүүн хамгийн ихдээ 100,000 еврогийн хадгаламжтай байх ба ХЗХ нь гишүүн бүрийнхээ нийт хадгаламжийг тооцож 100,000 еврогоос бага байгааг баталгаажуулдаг. Харин Австрали Улс нь хэрэглэгчдийн хадгаламжийг хамгаалах нэмэлт давхарга буюу Санхүүгийн нэхэмжлэлийн схемийг байгуулсан дэлхийн хамгийн тогтвортой санхүүгийн системтэй улс орон юм. Тус улсын санхүүгийн нэхэмжлэлийн схем нь хадгаламжийн байгууллагын данс эзэмшигч бүрийн 250,000 доллар хүртэлх хадгаламжийг хамгаалах Засгийн газрын дэмжлэгтэй хадгаламж хамгааллын томоохон схем юм.

Цаашлаад, зарим улс орнуудад чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь, зээлийн зохистой

харьцаа, хадгаламжийн нийт хөрөнгөд эзлэх хувь, нийт хөрөнгөд эзлэх үйл ажиллагааны зардлын хувь, нөөц сан болон хадгаламж хамгааллын сан, нэг гишүүний оруулсан хувь хөрөнгийн хэмжээнд зохистой харьцаа тогтоогоогүй байна. Хэдийгээр дээр дурдсан үзүүлэлтүүдэд зохистой харьцаа тогтоогоогүй ч ХЗХ нь жил бүр цэвэр ашгийн 10–20 хувийг нөөц санд байршуулах, мөн нийт гишүүдийн оруулсан хөрөнгийн 10 эсхүл 20 ба түүнээс дээш хувийг эзэмшдэг гишүүдийн мэдээллийг зохицуулагч байгууллагад мэдээлдэг. Ийнхүү олон улсын туршлагаас харахад улс орнуудын зохистой харьцааг тогтоосон байдал нь тухайн улсын санхүүгийн зах зээлийн бүтэц онцлогоос хамааран өөр өөр байна.

Иймд олон улсын туршлагад үндэслэн дараах зөвлөмжийг гаргаж байна:

- Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын зөвлөлөөс хадгаламж болон зээлийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг 70–80 хувь байлгахыг зөвлөдөг тул Монгол Улсад одоо мөрдөгдөж зохистой харьцааны хувь хэмжээг нийцүүлэх;
- Улс орнууд үйл ажиллагааны зардлын нийт хөрөнгөд эзлэх хувийг 5 хувиас хэтрэхгүй байхаар тогтоосон ба Монгол Улсын ХЗХ–дын дагаж мөрдөж буй тус харьцаа нь 15 хувь буюу бусад улс орнууд болон Дэлхийн зээлийн холбоодын зөвлөлөөс санал болгосон харьцаанаас 3 дахин өндөр байгаа нь ХЗХ–дыг үйл ажиллагааны өндөр зардал гаргах, цэвэр ашгийн хэмжээ буурах нөхцөлд хүргэж болзошгүй. Иймд тус харьцааг олон улсын стандартад нийцүүлэн өөрчлөх боломжийг судлан үе шаттайгаар бууруулах;
- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын

- зохистой харьцааг тооцох аргачлалыг PEARLS стандартад нийцүүлэх;
- Олон улсын туршлага, Монгол Улсын нөхцөлд тулгуурлан нэг гишүүний хадгаламжид зохистой харьцаа тогтоох талаар бодлогын арга хэмжээ авах;
- Олон улсын туршлагад үндэслэн ХЗХ тодорхой шаардлагыг хангасан тохиолдолд зарим зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн харьцааг нэмэгдүүлэх талаар бодлогын арга хэмжээ авах.

VI. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- APRA. “Financial Claims Scheme.” 2009. Available at: <https://www.apra.gov.au/financial-claims-scheme-0>
- Sian Murray et al. “Regulatory Capital for Irish Credit Unions: Time for Change?.” 2021. Available at: https://cuceoforum.ie/wp-content/uploads/2021/06/CEO-Forum-Regulatory-Capital-for-Irish-Credit-Unions-v1_0.pdf
- ICURN. “Central Bank of Ireland’s Performance of its Regulatory Functions in Relation to Credit Unions.” 2019. Available at: <https://www.centralbank.ie/docs/default-source/regulation/industry-market-sectors/credit-unions/communications/reports/icurn-peer-review-report.pdf>
- ARPA. “Regulations for Credit Unions.” 2018.
- Central bank of Ireland. “Credit union handbook.” 2018. Available at: Credit Union Handbook | Central Bank of Ireland
- The National Council. “The SACCO Societies Act.” 2022. Available at: <http://kenyalaw.org:8181/exist/rest/db/kenyalex/Kenya/Legislation/English/Acts%20and%20Regulations/S/SaccoSocieties%20Act%20-%20No.%2014%20of%202008/docs/SaccoSocieties-Act14of2008.pdf>
- Law Society of Kenya SACCA society Ltd. “Member share capital (increment) information.” 2019. Available at: <https://lks sacco.co.ke/wp-content/uploads/2020/01/LKS SACCO-MEMBER-SHARE-CAPITAL-INCREAMENT-INFORMATION-DOC-January-2020-1.pdf>
- WOCCU. “Technical Guide Credit Union Regulation and Supervision.” 2008. Available at: <https://www.findevgateway.org/sites/default/files/publications/files/mfg-en-toolkit-credit-union-regulation-and-supervision-technical-guide-2008.pdf>
- Financial Supervisory Service. “FSS handbook.” 2021. Available at: <https://www.bing.com/ck/a?!&p=37c798d3cb8d8ba9JmItdHM9MTcxNzExMzYwMzZpZD0x-ZTFjNjk1Ni1kNW11LTY1MDUtMDQ1My03YTcyZDRkNTY0ZWemaW5zaWQ9NTlyOA&ptn=3&ver=2&hsh=3&fclid=1e1c6956-d5b5-6505-0453-7a72d4d564ea&psq=FSS+handbook&u=a1aHR0cHM6Ly9lbmdsaXNoLmZzcY5vci5rci9lbmcyY21tbi9maWxlL2ZpbGVeb3duLmRvP-2F0Y2hGaWxISWQ9ZjMxNjA0YTQzMzMzNDM3YTljYzI5MjBmMzFjNzViMzYmZmlsZVNuPTE&ntb=1>

- Seung Yong Ahn. “Korean Credit Unions CSR and Social Finance.” 2018. Available at: <https://www.bing.com/ck/a?!&&p=77375b05cd2f222bJmItdHM9MTcxNzExMzYwMCZpZ3VpZD0x-ZTFjNjk1Ni1kNW11LTY1MDUtdMDQ1My03YTcyZDRkNTY0ZWEmaw5zaWQ9NTE50A&pt-n=3&ver=2&hsh=3&fclid=1e1c6956-d5b5-6505-0453-7a72d4d564ea&psq=Korean+Credit+Unions+CSR+and+Social+Finance&u=a1aHR0cHM6Ly93d3cuaXJ1LmRIL3dwLWNvbnRlbnQvdXBsb2Fkcy8yMDIwLzA2L1JhaWZmZWl3ZW5Ub2RheV9DaGFwdGVyMTRfU291dGgtS29yZWEucGRm&ntb=1>
- Laws of Kenya. “Co-Operative Societies Act.” 2012. Available at: <https://www.bing.com/ck/a?!&&p=9710a4dfacf2145fJmItdHM9MTcxNzExMzYwMCZpZ3VpZD0x-ZTFjNjk1Ni1kNW11LTY1MDUtdMDQ1My03YTcyZDRkNTY0ZWEmaw5zaWQ9NTIxNQ&pt-n=3&ver=2&hsh=3&fclid=1e1c6956-d5b5-6505-0453-7a72d4d564ea&psq=Co-Operative+Societies+Act&u=a1aHR0cDovL3d3dy5rZW55YWxhdy5vcmcva2wvZmlsZWZkbWl3L3BkZmRvd25sb2Fkcy9BY3RzL0NvLW9wZXJhdGkiZ2VnYy2IldGllc0FjdENhcDQ5MC5wZGY&ntb=1>
- Laws of Trinidad and Tobago. “The credit unions (prudential criteria) regulations” 2012. Available at: No (central-bank.org.tt)
- Central Bank of Trinidad and Tobago. “The policy proposal document for the Credit Union Act.” 2009.
- Санхүүгийн зохицуулах хороо. “ХЗХ-дын 2024 оны нэгдүгээр улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга.” 2024. Эх үүсвэр: <http://www.frc.mn/resources/Images/Document/202402/0FnCx/SCC-netgtel-2023.IV---Huraangui.pdf>